

47



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 61

Номгон

**Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах аймгийн
дэд зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах аймгийн дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Аймгийн Цагдаагийн газрын дарга

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Аймгийн Прокурорын газрын Ерөнхий прокурор

Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга

Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

Аймгийн Автотээврийн төвийн дарга

“Их богд зам” ХХК-ний ерөнхий инженер (зөвшилцснөөр)

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр болон холбогдох дүрэм, журмын хүрээнд тодорхой ажил, арга хэмжээг үр дүнтэй, бодитой зохион байгуулж, үр дүнг хагас, бүтэн жилээр танилцуулж ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсангай холбогдуулан 2018 оны 104 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ



0121100